



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 1/242
танай _____ -ны № _____ -т

**БАЯНХОНГОР СУМЫН 8 ДУГААР БАГИЙН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.АМАРСАНАА ТАНАА**

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг
хүргүүлж байна.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг
2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Хавсралт ¹⁸ хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



6425030428



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/136/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2025 оны 02 дугаар сар 10

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com
Аудитор: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүү	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Худалдан авах ажиллагааны талаар	17
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6.1 Завсрын аудитын талаар	17
4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.17 № 100.
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд 1,066,248.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 866,671,5 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 548.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, нийт 204,136.1 мянган төгрөгийн мөнгө хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитаар сургуулийн хүүхдийн дотуур байрны хоолны материалын зардлаас үдийн хоолны материалын зардалд 411.0 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн зарцуулсан зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс даваагүй байгаа нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

622502050

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 91.8 хувьтай тайлагнасныг 84.8 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	122,161,323.02	243,220,006.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	83,303,055.02	204,136,083.02
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	83,303,055.02	204,136,083.02
31210	Төгрөг	83,303,055.02	204,136,083.02
31211	Төрийн сангийн харилцах	83,303,055.02	204,136,083.02
35	БАРАА МАТЕРИАЛ	38,858,268.00	39,083,923.50
35100	Түүхий эд материал		119,200.00
35130	Эм боох материал		119,200.00
35400	Хангамжийн материал	38,858,268.00	38,964,723.50
35420	Аж ахуйн материал	57,100.00	67,500.00
35460	Хүнсний материал	9,095.00	1,805.00
3547003	бусад хангамжийн материал	37,787,083.00	35,852,583.00
3547004	бусад хангамжийн материал/ сурах бичиг	1,004,990.00	3,042,835.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	484,295,568.07	452,965,849.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	484,295,568.07	452,965,849.10
39200	Биет хөрөнгө	473,439,568.07	442,109,849.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	454,391,414.55	480,033,014.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-142,077,343.00	-169,739,824.93
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	127,268,176.00	146,185,776.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,418,434.78)	(69,191,530.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,566,016.80	86,566,016.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,103,974.43)	(55,730,928.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,772,322.60	67,772,322.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(55,563,658.19)	(58,390,045.31)
39217	Ном	14,605,048.52	14,605,048.52
39300	Биет бус хөрөнгө	10,856,000.00	10,856,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,856,000.00	10,856,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	606,456,891.09	696,185,855.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	434,535,590.06	434,535,590.06
51	Засгийн газрын хувь оролцоо	434,535,590.06	434,535,590.06
51100	Засгийн газрын оруулсан капитал	434,535,590.06	434,535,590.06
51101	өмч-Төрийн өмч	434,535,590.06	434,535,590.06
51200	Хуримтлагдсан үр дүн	-77,404,165.10	12,324,799.43
51210	Өмнөх үеийн үр дүн	(77,404,165.10)	(77,404,165.10)
51220	Тайлант үеийн үр дүн		89,728,964.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	249,325,466.13	249,325,466.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	606,456,891.09	696,185,855.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

БНА-2025/136/НА-СТА-ТШЗ



Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	703,523,790.00	1,032,801,045.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,188,690.00	45,436,545.50
120	Нийтлэг татварын бус орлого	86,188,690.00	45,436,545.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,000.00	140000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	140000
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	83,963,500.00	43,019,200.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,050,190.00	2,277,345.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	617,335,100.00	987,364,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	561,397,600.00	921,870,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	561,397,600.00	921,870,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,937,500.00	65,494,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,937,500.00	65,494,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	660,142,358.80	943,072,080.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	660,142,358.80	943,072,080.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	638,632,753.21	921,454,594.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,496,342.76	653,194,858.74
210101	Үндсэн цалин	311,249,704.76	408,508,453.74
210102	Нэмэгдэл	107,041,185.00	214,466,037.00
210104	Урамшуулал	19,205,453.00	30,220,368.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,471,571.07	77,002,621.16
210201	Тэтгэврийн даатгал	35,831,503.92	53,667,285.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,361,948.60	6,144,060.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,489,558.91	3,072,030.91
210204	Ажилгүйдлийн даатгал	779,854.20	2,658,550.34
210205	Эрүүл мэндийн даатгал	8,008,705.44	11,460,693.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,122,894.41	61,029,913.60
210301	Гэрэл, цахилгаан	4,930,435.31	5,998,061.00
210302	Түлш, халаалт	48,192,459.10	55,031,852.60
2104	Хангамж, бараа материалын зардал	8,951,800.00	16,621,100.00
210401	Бичиг хэрэг	3,053,200.00	5,244,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,898,600.00	7,979,450.00
210408	Бараа материал акталсны зардал		3,397,500.00
2105	Нормативт зардал	18,919,000.00	17,337,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		101,700.00
210502	Хоол, хүнс	18,919,000.00	17,236,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,958,500.00	788,000.00

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,958,500.00	788,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	5,317,843.53
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	5,317,843.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,212,644.97	90,162,557.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,118,600.00	14,226,338.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		47300
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,094,044.97	75,888,918.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,165,000.00	21,069,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,165,000.00	21,069,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,165,000.00	21,069,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	344,605.59	548,486.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	344,605.59	548,486.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	43,381,431.20	89,728,964.53
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ҮР ДҮН (IV)	4,191,709.23	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,191,709.23	
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	39,189,721.97	89,728,964.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	617,510,100.00	987,504,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,000.00	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	175,000.00	140,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,000.00	140,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175000	140,000.00
120009	Бусад орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	561,397,600.00	921,870,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	561,397,600.00	921,870,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	561,397,600.00	921,870,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,937,500.00	65,494,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,937,500.00	65,494,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	602,271,263.83	865,131,472.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	602,271,263.83	865,131,472.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	581,795,958.24	843,623,185.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,496,342.76	653,194,858.74
210101	Үндсэн цалин	282,864,793.89	377,381,863.65
210102	Нэмэгдэл	134,903,001.09	245,782,325.09
210104	Урамшуулал	19,728,547.78	30,030,670.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,471,571.07	77,002,621.16
210201	Тэтгэврийн даатгал	36,084,026.35	52,658,451.78
210202	Тэтгэмжийн даатгал	4,247,000.46	6,141,918.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,397,560.38	3,068,164.65
210204	Ажилгүйдлийн даатгал	776,943.86	2,986,237.79
210205	Эрүүл мэндийн даатгал	7,966,040.02	12,147,848.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,122,894.41	61,029,913.60
210301	Гэрэл, цахилгаан	4,930,435.31	5,998,061.00
210302	Түлш, халаалт	48,192,459.10	55,031,852.60
2105	Нормативт зардал	19,959,150.00	17,337,910.00

**Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	19,959,150.00	17,337,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,470,000.00	3,916,000.00
210604	Урсгал засвар	2,470,000.00	3,916,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	5,317,843.53
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	5,317,843.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,776,000.00	25,824,038.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,447,800.00	21,359,638.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,328,200.00	4,464,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,130,700.00	20,959,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,130,700.00	20,959,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,130,700.00	20,959,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	344,605.59	548,486.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	344,605.59	548,486.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,238,836.17	122,373,028.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	12,028,200.00	1,540,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,028,200.00	1,540,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,028,200.00	1,540,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,028,200.00	1,540,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(12,028,200.00)	(1,540,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,210,636.17	120,833,028.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	80092418.52	83,303,055.02
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	83,303,055.02	204,136,083.02

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	(77,404,165.10)	606,456,891.09
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	-77,404,165.10	606,456,891.09
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	-77,404,165.10	606,456,891.09
19	Тайлант үеийн үр дүн			89,728,964.53	89,728,964.53
20	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	12,324,799.43	696,185,855.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,066,243,200.0	866,122,985.5	200,120,214.5	81.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,066,243,200.0	866,122,985.5	200,120,214.5	81.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,042,020,400.0	845,163,185.5	196,857,214.5	81.1



Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	804,523,900.0	653,194,858.65	151,329,041.4	81.2
210101	Үндсэн цалин	568,168,700.0	377,381,863.65	190,786,836.4	66.4
210102	Нэмэгдэл	221,972,800.0	245,782,325.00	-23,809,525.0	110.7
210104	Урамшуулал	14,382,400.0	30,030,670.00	-15,648,270.0	208.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,565,400.0	77,002,621.16	23,562,778.8	76.6
210201	Тэтгэврийн даатгал	68,384,500.0	52,658,451.78	15,726,048.2	77.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,045,200.0	6,141,918.22	1,903,281.8	76.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,022,600.0	3,068,164.65	954,435.4	76.3
210204	Ажилгүйдлийн даатгал	4,022,600.0	2,986,237.79	1,036,362.2	74.2
210205	Эрүүл мэндийн даатгал	16,090,500.0	12,147,848.72	3,942,651.3	75.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,578,400.0	61,029,913.6	548,486.4	99.1
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.0	5,998,061.0	1,939.0	100.0
210302	Түлш, халаалт	55,494,400.0	55,031,852.6	462,547.4	99.2
210303	Цэвэр, бохир ус	84,000.0		84,000.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,916,000.0	3,916,000.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	3,916,000.0	3,916,000.0	0.0	100.0
2105	Нормативт зардал	27,452,700.0	17,337,910.0	10,114,790.0	63.2
210502	Хоол, хүнс	27,452,700.0	17,337,910.0	10,114,790.0	63.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,334,200.0	6,857,843.5	4,476,356.5	60.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,334,200.0	6,857,843.5	4,476,356.5	60.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,649,800.0	25,824,038.6	6,825,761.4	79.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,185,400.0	21,359,638.6	6,825,761.4	75.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,464,400.0	4,464,400.0	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,222,800.0	20,959,800.0	3,263,000.0	86.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,222,800.0	20,959,800.0	3,263,000.0	86.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,222,800.0	20,959,800.0	3,263,000.0	86.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,066,243,200.0	1,061,400,800.0	4,842,400.0	99.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	921,870,100.0	921,870,100.0	0.0	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	921,870,100.0	921,870,100.0	0.0	100.0
310002	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,494,400.0	65,494,400.0	0.0	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	140,000.0	140,000.0	0.0	100.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.0	140,000.0	0.0	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	78,738,700.00	73,896,300.0	4,842,400.0	93.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	80,092,418.9	83,303,055.0	-3,210,636.2	104.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	83,303,055.0	204,136,083.0	120,833,028.0	245.1
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			0.0	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.0	25.0	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21.0	.0	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8.0	8.0	0.0	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	170.0	168.0	-2.0	98.8
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	170.0	168.0	-2.0	98.8
630001	Төрийн өмчит ЕБС	170.0	168.0	-2.0	98.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба гэсэн бүтэц зохион байгуулалттай 30 орон тоотой, 168 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай “ 25 дугаар тогтоолын хавсралт” Боловсролын байгууллагын үйл ажиллагааны олон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр журам батлах тухай” 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84, “Төрийн албаны зарим



албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газар болон аймгийн Боловсролын газраас хяналт, шинжилгээ, дотоод аудитын шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-1 ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89,729.0 мянган төгрөгөөр буюу 14.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	83,303	204,136.10	120,833.10
Авллага	0	0	0.00

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бараа материал	38,858.3	39,083.9	225.6
Үндсэн хөрөнгө	761,458.90	806,018.2	44,559.3
Хуримтлагдсан элэгдэл	-277,163.4	-353,052.3	-75888.9
Нийт хөрөнгө	606,456.90	696,185.90	89,729.00
Өр төлбөр	0.00	0	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	606,456.90	696,185.90	89,729.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	606,456.90	696,185.90	89,729.00

Эх сурвалж: Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь бараа материал, мөнгөн хөрөнгө ,үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 83,303.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 204,136.1 мянган төгрөгийн өмнөх оноос 120,833.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 53,764.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна

Мөн 2,277.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 52,418.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж “Бусад хангамжийн материалыг актлаж данснаас хасах тухай” захирлын 2024 оны 12 дугаар сарн 20-ны өдрийн А/14 дугаар тушаалаар 3,397.5 мянган төгрөгийн бараа материал актлаж бараа материалын үлдэгдэл 225.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,540.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 17,377.6 мянган төгрөгийн хөрөнгийг машин тоног төхөөрөмжийн дансанд , Баянхонгор аймгийн ИТХурлын даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн “Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай” А/25 дугаар захирамжаар 20,000.0 мянган төгрөгийн спорт заалны шалны засвар, Шаргалжуут рашаан сувилалаас сургуулийн 00 асуудлыг шийдвэрлэн 5,641.6 мянган төгрөгийн жорлонг барилга байгууламжийн дансанд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгөнд орлого бүртгэн 44,559.3 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Тайлант онд авлага, өглөггүй ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 89,729.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 696,185.9 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 89,729.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 696,185.9 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 747,761.7 мянга, орон нутгаас авах санхүүжилтийг 84,755.8 мянган төгрөг нийт санхүүжилт 832,517.6 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 832,517.6 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 289,883.6 мянган төгрөгөөр буурч 542,633.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор улсын төсөв 542,870.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн төсвөөс 19,261.4 мянган төгрөг хасагдаж 1,066,243.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 921,870.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 78,878.7 мянга, үйл ажиллагааны орлогоос 140.0 мянга, орон нутгийн төсвөөс 65,494.4 мянган төгрөг нийт 1,066,234.2 мянган төгрөгийн эх үүсвэртэй гүйцэтгэлээр 866,671.5 мянган төгрөгийг зарцуулж, 204,136.1 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 65,494.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99.1 хувь буюу 64,945.9 мянган төгрөгийг зарцуулж, 548.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	1,190.90	1,190.90	0.0	100.00%
2	80233 Хүүхэд хамгаалал	1,261.20	484.20	777.0	
3	80312 Сургалт семинар	1,897.00	1,897.00	0.0	100.00%
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	2,124		2,124.4	0.00%
5	81801 Үдийн цай хөтөлбөр	24,223	20,959.8	3,263.0	86.53%
6	81806 Дотуур байр	148,748	127,818.0	20,929.8	85.93%
7	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	9,575	9,272.00	303.0	96.84%
8	81823 Боловсролын байгууллагын багш	3,273.20		3,273.2	0.00%
9	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	7,952.70	6,214.70	1,738.0	78.15%
10	81834 Боловсролын стандарт, сургалтын	784,322	619,450.30	164,871.5	78.98%
11	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	14,011.20	12,751.20	1,260.0	91.01%
12	81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр	2,030.80	998.90	1,031.9	49.19%
13	81844 Гүнгзгийрүүлсэн болон төрөлж	140.00	140.00	0.0	100.00%
14	80112 Нийтлэг үйлчилгээ	65,494.40	65,494.40	0.0	100.00%
15	2023 оны харицахын үлдэгдэлээс			4,564.3	
ДҮН		1,066,243.20	866,671.40	204,136.1	81.28%

Эх сурвалж: 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон Аудит ХХК-ийн захирал, аудитор Г.Саранчимэг багийг ахалж аудитор О.Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, Өвөрхангай аймгийн газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Н.Амарсанаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Одгэрэл нар зурж, нярваар Т.Сүглэгмаа нар ажиллажээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг оны батлагдсан төсөв 1,066,243.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,662.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,996.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 987,539.9 мянган төгрөгийн 25 гүйлгээ, зарлагын 54,801.8 мянган төгрөгийн 7 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Худалдан авах ажиллагааны талаар

Тус сургууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үнэлгээний хороог захирлын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/02 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдхүүнтэй томилж дотуур байрны хүүхдийн хоол 20,916.0 мянга, үдийн хоолны 22,491.0 мянган төгрөгийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерыг харьцууллын аргаар зохион байгуулахаар 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл ажлын 5 хоногт багтан худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна.

Үдийн хоолны материал нийлүүлэх тендерийг 4 багц, дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерийг 4 багц болгон зарласан байна

Үдийн хоолны материал нийлүүлэх 2 багц, дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх 2 багц тендерт Софтвишн ХХК компани шалгарч багц-1 13,307.0 мянга, багц-2 7,207.0 мянган төгрөгөөр нийт 20,514.0 мянган төгрөгийн бараа материал нийлүүлэх гэрээг 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс 2025 оны тендер зарлах хугацаа хүртэл байгуулан ажилласан байна.

Багц-4 Мах, махан бүтээгдхүүн, багц-3 сүү сүүн бүтээгдхүүн нийлүүлэх тендерийг 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ны өдөр хүртэлх хугацаанд дахин зарлаж Жава-плас ХХК шалгаран 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдөр гэрээ байгуулан ажилласан байна. Худалдан авах гэрээний үнийн дүнг мөрдөн ажиллаж гэрээг дүгнэн ажилласан байна.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.6.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Номгон аудит ХХК-ийн аудитор Г. Саранчимэг гүйцэтгэж зөрчилгүй ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,955.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд 411.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1544.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага тогтоов.

5.1 Төлбөрийн акт

1.Дотуур байрны хүүхдийн хоолны материалын зардлаас үдийн хоолны материалын зардалд 411.0 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардал болон гүйцэтгэл үр дүнд суурилан санхүүжүүлэх журмын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангилалын дэлгэрэнгүй заавар, Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Ангилал шинэчлэн батлах тухай 211 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, дах заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн ангилал зөрчин дотуур байрны хүүхдийн хоолны материалын зардлаас үдийн хоолны материалын зардалд зарцуулсан 411.0 мянган төгрөгийг үдийн хоолны зардлаас төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1. Боловсрол Шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 2/2772 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 07 дугаар 09-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/42 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6,4,1 -төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл		/мянган төгрөгөөр/							
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил									
Дотуур байрны хүүхдийн хоолны материалын зардлаас үдийн хоолны материалын зардалд 411.0 мянган төгрөгийг материал шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” 39 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын заалттай нийцэхгүй байна.									
1	411.0	1	411.0						
Төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6,4,1 -төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 заалттай нийцэхгүй байна.									
1	1,544.0			1	1544.0				
Нийт дүн									
2	1955.0	1	411.0	1	1544.0				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 33/14225456/БНА-2025/136/ Номгон
НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсрол Шинжлэх ухааны яамны 2024.06.24-ны өдрийн 2/2772 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Боловсролын газрын даргын 2024.07.09-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/42 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544,000 (Нэг сая таван зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6,4,1 төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах мөн 16,5,5 - батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:


5040098

1. Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох , зөрчлийг арилган биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн захирал Н. Амарсанаа, нягтлан бодогч Б.Одгэрэл нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  **Б.МӨНХБАТ**

НОМГОН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТОР: 

О.МАНДАХ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 12/14225456/БНА-2025/136/ Номгон
НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотуур байрны хүүхдийн хоолны материалын зардлаас үдийн хоолны материалын зардалд 411,000 төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардал болон гүйцэтгэл үр дүнд суурилан санхүүжүүлэх журмын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар, Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Ангилал шинэчлэн батлах тухай 211 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, дах заалтуудыг зөрчиж Үнэн ба зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь

5050051

“Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 411,000/ дөрвөн зуун арван нэгэн/ төгрөгийг үдийн хоолны зардлаас төлүүлж төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Амарсанаа, нягтлан бодогч Б.Одгэрэл нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

НОМГОН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТОР:

О.МАНДАХ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно